



**ЗАВХАН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2023 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 70

Улиастай

Аймгийн 2023 оны төсвийн тодотгол  
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.9, 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Завхан аймгийн 2023 оны төсвийн жилд зарцуулах төсвийн зарлагын хэмжээг 2.309.360.0 мянган төгрөгөөр тодотгон баталж, төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн харьяа байгууллагад дор дурдсан төсөв зарцуулах эрх олгосугай.

/мянган төгрөг/

1.1	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	170.000.0
1.2	Аймгийн Засаг даргын Тамгын газар	309.760.0
1.2.1	Үүнээс: Засаг даргын нөөц сан	250.000.0
1.3	Орон нутгийн хөгжлийн сан	421.600.0
1.4	Орон нутгийн хөрөнгө оруулалт	1.408.000.0

2. Аймгийн 2023 оны төсвийн тодотголын санхүүжүүлэх эх үүсвэрийг урьд оны үлдэгдэлээс 2.309.360.0 мянган төгрөгөөр баталсугай.

3. Батлагдсан төсвийг үр ашигтай зарцуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллан төсвийн гүйцэтгэлийг 2023 оны 12 дугаар сард ИТХ-ын

810903011

хуралдаанд тайлагнахыг аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагч Засаг дарга /Д.Түвшинжаргал/-д даалгасугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн ИТХ-ын ажлын алба /С.Болдбаатар/-д үүрэг болгосугай.

ДАРГА  Н.ТАМИР

